

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах” тухай Монгол Улсын Шадар сайд М.Энхболдын илтгэлийн баримт бичигтэй ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, нэгдсэн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,

2. Ашиглалтын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөн шинэчлэх, аюулгүй нөхцөлөөр хангахтай холбогдсон эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг дэс дараатай шийдвэрлэх.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,

2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйлдвэр, үйлчилгээ, хүн амын суурьшлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,

4. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, бусад шийдвэрийн биелэлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 22-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд илтгэж байх.